

4. Та 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөтэй эсэх: <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй		
Валютын нэр	Нийт дүн	
	Тоогоор	Үсгээр

ЗОРЧИГЧИЙН АНХААРАЛД

- 1.Зорчигч та доор дурьдсан бараатай бол энэ мэдүүлгийг бөглөж, улаан гарцаар нэвтэрнэ.
- 2.16 нас хүрээгүй зорчигчийн барааг эцэг эх, асран хамгаалагчийн гаалийн мэдүүлэгт бичнэ.
- 3.Бусдад дамжуулах бараа нь зорчигчийн бараанд тооцогдоно.
- 4.Зорчигч дараах тоо хэмжээ бүхий барааг гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх эрхтэй : Архи, дарс тус бүр 2 литр, пиво 3 литр, янжуур 200 ш, сигар навчин тамхи 50 ш, задгай тамхи 250 граммаас илүүгүй.
- 5.18 нас хүрээгүй зорчигчид согтууруулах ундаа, тамхи нэвтрүүлэхийг зөвшөөрөхгүй.
- 6.Зорчигч энэ мэдүүлгийн 2 болон 4-т дурдсан барааг мэдүүлсэн бол 2 хувь бичнэ.
- 7.Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон, тарифын болон тарифын бус хязгаарлалттай барааг худал, эсхүл дутуу мэдүүлсэн, огт мэдүүлэхгүй хууль бусаар гаалийн хилээр нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.Хориглосон бараа:

- 1.Мансууруулах бодис, тэдгээрийг хэрэглэх, үйлдвэрлэхэд зориулсан багаж хэрэгсэл, мансууруулах ургамал нэвтрүүлэх;
- 2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйл нэвтрүүлэх;
- 3.Зөвшөөрөлгүй химийн хорт болон аюултай бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл, донорын цус, эд эрхтэн, өвчин үүсгэгч нян нэвтрүүлэх;
- 4.Түүх соёлын хосгүй үнэт зүйл гаргах;
- 5.Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн эд зүйл хууль бусаар нэвтрүүлэх.

6.Гаалийн байгууллагад мэдүүлэх бараа:

- 1.Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, ан амьтны холбогдолтой судалгааны ажлын сорьц, дээж, хилээр нэвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан бараа;
- 2.Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологи, угсаатны зүй болон зоос судлалын чиглэлийн олдвор, цуглуулга, төрийн одон медаль;
- 3.Алт, мөнгө, байгалийн төрхөөрөө байгаа болон боловсруулалт хийгдсэн үнэт металл, эрдэнийн чулуу, байгалийн болон гоёлын чулуу;

- 4.15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгө;
- 5.Шинжлэх ухаан, техникийн ололт, газар нутгийн дүрс, зураг зүйн бусад материал, судалгаа шинжилгээний материал;
- 6.Галт зэвсэг, пиротехникийн хэрэгсэл, хутга, хүйтэн зэвсэг;
- 7.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис;
- 8.Химийн болон цацраг идэвхит бодис;
- 9.Боловсруулаагүй дахин боловсруулалт хийх бараа, үйлдвэрлэлийн зориулалттай бараа, түүхий эд, бүх төрлийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, барилгын материал;
- 10.Бусдад дамжуулах бараа;
- 11.Биеэс тусдаа илгээсэн ачаа;
- 12.Арилжааны шинж чанартай бараа.

Зорчигчийн гаалийн мэдүүлгийг үнэн зөв бичсэн:
Гарын үсэг Он ____ сар ____ өдөр ____

Гаалийн тэмдэглэгээ:
Гаалийн улсын байцаагчийн Хувийн тэмдэг гарын үсэг

Гаалийн хууль тогтоомж болон энэ мэдүүлгийн талаар тодруулах зүйл байвал гаалийн улсын байцаагчид хандана уу.

Хуулиа сахин мөрдөж, бидэнтэй хамтарч ажилласан

Танд баярлалаа!

(1800-1281 ГААЛЬ СОНСОЖ БАЙНА